

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|--|----|
| 1.Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 7 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 8 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 9 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 9 |
| 3. Менежментийн захидал..... | 10 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 12 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 12 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 14 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 16 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 18 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 19 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 21 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 22 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ЗГ | Засгийн газар |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СЭРГЭЭН ЗАСАЛТ, СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ДАРГА
С.БАЯРБАТ ТАНАА

2020.08.21 № 06/558
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга С.Баярбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шатахууны зарцуулалт, бараа материалын тооллого, үйлдвэрлэлийн өртөг, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх төрийн бодлого, хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, протез ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэх, сэргээн засах эмчилгээ болон хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх, амьдрах чадварыг сайжруулах” зорилтыг гол зорилгоо болгон ажиллаж байна.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сэргээн засах төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нас, хүйс, харьяалал харгалзахгүй хүлээн авч, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоо, эмчилгээний цогц үйлчилгээг үзүүлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгож, тэдэнд харилцааны ур чадвар, амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, биеийн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг онол, дадлага хослуулан явуулах.
- Протез, ортопедийн үйлдвэр нь тус хөгжлийн бэрхшээлтэй хүний төрөл хэрэгцээнд нийцсэн чанартай, хүртээмжтэй олон улсын стандартад тохирсон протез, ортопедийн хэрэгслийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан үйлдвэрлэх, ханган нийлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “ACOULOS” программ хангамж ашигладаг.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,677,426.2 мянган төгрөгөөс тооцон 33,548.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 52,180.5 мянган төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын хэмжээнээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 722,400.2 мянган төгрөгөөр буюу 17.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс урьдчилж төлсөн зардал, авлага, үндсэн хөрөнгийн данс материаллаг өөрчлөлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 492.1 | | (492.1) |
| Авлага | 9,073.4 | 1,241.4 | (7,832.0) |
| Урьдчилж төлсөн зардал | 23,716.6 | | (23,716.6) |
| Бараа материал | 419,668.9 | 416,770.3 | (2,898.5) |
| Үндсэн хөрөнгө | 3,726,919.0 | 3,039,458.0 | (687,461.0) |
| Нийт хөрөнгө | 4,179,869.9 | 3,457,469.7 | (722,400.2) |
| Өр төлбөр | 99,470.1 | | (99,470.1) |
| Урьдчилж орсон орлого | 47,691.9 | 30,759.6 | (16,932.3) |
| Засгийн газрын хувь оролцоо | 4,032,707.9 | 3,426,710.1 | (605,997.8) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,179,869.9 | 3,457,469.7 | (722,400.2) |

Авлага дансны үлдэгдэл 7,832.0 мянган төгрөгөөр буурсан нь 2013 онд үүссэн 6,600.0 мянган төгрөгийн протезийн авлагыг мөнгөөр, 2016 онд үүссэн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг илүү олгосон 1,232.0 мянган төгрөгийг цалин хөлснөөс суутган тооцож бууруулан ажилласан байна.

Урьдчилж төлсөн зардлын 2017-2018 онд үүссэн тооцоог улсын мэдээллийн маягт 51,466 ширхэг 10,167.3 мянган төгрөгөөр хэвлүүлж, 10,288 ширхэг 13,549.2 мянган төгрөгийн үйлдвэрийн түүхий эд материал хүлээн авч нийт 23,716.5 мянган төгрөгөөр бууруулан ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,898.5 мянган төгрөгөөр буурсан нь протез, ортопедийн үйлдвэрлэлийн 2019 он хүртэлх захиалгыг бүрэн барагдуулахын тулд үйлдвэрлэлээ нэмэгдүүлснээс шалтгаалжээ. Оны эцэст бараа материалын дансанд 228,978.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь тусгай зориулалтын материалд 97 нэр төрлийн 261,807.2 мянган төгрөг, эм боох материалын 172 нэр төрлийн 24,778.6 мянган төгрөг, бичиг хэргийн материалын 18 нэр төрлийн 9,072.2 мянган төгрөг, бусад хангамжийн материалын 143 нэр төрлийн 120,041.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 3 болон 4 сард батлан, 4 болон 5 сард гэрээ хийгдэн нийлүүлэгддэг тул оны эхний шаардлагатай материалыг оны эцэст худалдан авч бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,464.0 мянган төгрөгөөр өссөн нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 10 ширхэг компьютер, техник хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 32,007.3 мянган төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн өглөг 1,586.7 мянган төгрөг, эмнэлэг сургуулийн хоолны тооцооны өглөг 17,451.8 мянган төгрөг, эмийн тооцооны өглөг 34,681.6 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант онд төлж өр төлбөрийг 85,727.4 мянган төгрөгөөр бууруулсан байна. Мөн протез, ортопедийн үйлдвэрийн захиалгын урьдчилгаа 47,691.9 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг захиалагчид хүлээлгэн өгч урьдчилж орсон орлогын өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,426,710.1 мянган төгрөг болж 605,997.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 235,019.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 631,110.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 130,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс санхүүжих орлого 12,542.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь өндөр насны тэтгэвэрт гарах ажилтны тэтгэвэр хойшлогдсоноос 11,808.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын санхүүжилт 733.4 мянган төгрөг олгогдоогүйгээс шалтгаалсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлогын төлөвлөгөө нь 50,197.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ”-нд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 20 орыг /үнэлгээ 300.0 мянган төгрөг/ сэргээн засах тусламж, үйлчилгээний ороор /үнэлгээ 110.0 мянган төгрөг/ болгон өөрчилснөөс шалтгаалсан.

Үндсэн үйл ажиллагааны орлогын санхүүжилт 15,310.4 мянган төгрөгөөр давсан нь протез, ортопедийн үйлдвэрийн өмнөх оны урьдчилж орсон орлогын үлдэгдлийг бууруулахаар үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төсвийн дагуу зарцуулж 46,937.2 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдээсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нийт зардлын 1,235,019.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 631,110.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 130,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тэтгэвэрт гарах ажилтан хойшлогдсоноос шалтгаалан тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 11,808.9 мянган төгрөгөөр, урьд оны авлагатай байгууллагаас улсын мэдээллийн маягтыг бэлтгүүлснээс 5,936.4 мянган төгрөгийг тус бүр хэмнэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,917,910.1 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь төсвийг 78,219.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, 31,732.2 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 4,002.0 мянга төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 350.0 мянган төгрөг, нийт 4,352.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 1,900.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 2,002.0 мянган төгрөг нийт 3,902.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 450.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 375,853.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 343,982.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,022.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 25,848.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн үе шатанд үндсэн хөрөнгийн элэгдэл 332,684.0 мянган төгрөгийг тооцоогүй, хандив тусламжаар хүлээн авсан 11,298.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нийт 343,982.8 мянган төгрөгийн зөрчлийг тус бүр залруулсан болно.

2. Тайлант хугацаанд шатах, тослох материалын нярвын тайланг бэлтгэхдээ авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг сар тутам тооцоогүй, 6022,4 мянган төгрөгийн шатахууны тайланг зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан " Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт, УСНББОУ -ийн 29-д "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитаар илэрсэн 25,848.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвд улсын бүртгэлтэй холбоотой 2 асуудал байна. Үүнд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээнд улсын төсөвт үйлдвэрийн газар, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг сургалтын ажил эрхлэхээр бүртгүүлсэн байна. Харин 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ХНХЯамны сайдын А/24 тушаалаар батлагдсан дүрмээр Сэргээн засах төв эмнэлэг, Протез, ортопедийн үйлдвэр, Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуультай байхаар үндсэн үйл ажиллагааг заасан байна. Иймд үйл ажиллагааны чиглэлээ дүрмэнд зааснаар өөрчлөн бүртгүүлэх.

Дээрх асуудлуудыг улсын бүртгэлд бүртгүүлж өөрчлөлтийг хийсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг байршуулахаас 147 мэдээлэл байршуулж, 2 мэдээлэл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Байршуулсан мэдээллээс 3 мэдээ хугацаа хоцроосон байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,210.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

“Зөрчилгүй” дүгнэлт

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн бараа материалын тооллогын илтгэх хуудсанд 25,848.6 мянган төгрөгийн эм боох материалын үлдэгдлийг тусгалгүй, үр дүнг баталгаажуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, мөн 72.4.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг тус бүр хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

1.2. Эрсдэл:

Байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн тооллогыг үр дүнтэй чанартай хийж бүх шатны хяналтыг хэрэгжүүлж зохион байгуулж ажиллахыг зөвлөж байна.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тооллогын чанартай хийж гүйцэтгэн, үр дүнг хэлэлцэн бараа материалын хяналтаа сайжруулан ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тусгай зориулалтын материал буюу протез, ортопедийн материалын зардлыг үйлдвэрлэлд шилжүүлэхдээ зөвхөн материалын зарцуулалтыг бүртгэж байгаа бөгөөд санхүүгийн программ хангамжаас шалтгаалан дуусаагүй үйлдвэрлэл дансанд хувиргалтын зардал болох цалин хөлс, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг хуримтлуулан

өртгийг бүртгээгүй байна. Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт 2.3-т "Анхан шатны баримтаас зардлын мэдээг тодорхойлон бүртгэлийн системд боловсруулан ерөнхий дэвтрийн дансанд бүртгэнэ. Ерөнхий дэвтрийн зардлын бүх дансанд тухайн тайлант хугацааны зардлууд бүрэн бүртгэгдсэн байх ёстой" гэсэн заалт, УСНББОУС 12-ын 20-д зааснаар бараа материалыг бэлэн бүтээгдэхүүнд хувиргахад гарсан тогтмол болон хувьсах зардал, нэмэгдэл зардлыг хуримтлуулж өртөг тооцно гэснийг зөрчиж байна.

2.2. Эрсдэл:

Байгууллагын ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд орлого, зардлыг үнэн зөв хуваарилсан байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Тусгай хэрэгслийн үйлдвэрлэлийн өртгийг тооцохдоо УСНББОУС 12 мөрдөж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Санхүүгийн тооцоолох ХХК-д танилцуулан программ шинэчлэгдвэл хэрэгжүүлэхэд бэлэн байна.

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд боловсруулагдсан бөгөөд тухайн байгууллагын онцлог, эмнэлгийн үйл ажиллагаа, сургалтын үйл ажиллагаа болон мөрдөгдөж байгаа дүрэм журам, стандартын өөрчлөлтийг бүрэн тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь дүрэм журам, стандарттай нийцэхгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг стандарт, хууль дүрэм журмын шинэчлэлийг хийж боловсруулж мөрдөх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 452,950,765.89 | 418,011,717.89 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 492,019.00 | - |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 491,075.00 | - |
| 31110 | Төгрөг | 491,075.00 | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 944.00 | - |
| 3121 | Төгрөг | 944.00 | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 944.00 | |
| 33 | АВЛАГА | 9,073,415.00 | 1,241,400.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,441,400.00 | 1,241,400.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 6,600,000.00 | |
| 335 | Бусад авлага | 32,015.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 32,015.00 | |
| 34 | УРЬДЧИЛГАА | 23,716,550.00 | - |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 23,716,550.00 | - |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 23,716,550.00 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 419,668,781.89 | 416,770,317.89 |
| 351 | Түүхий эд материал | 277,584,894.31 | 286,585,800.42 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 254,100,486.75 | 261,807,230.78 |
| 35130 | Эм боох материал | 14,431,995.56 | 24,778,569.64 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 8,117,080.00 | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 935,332.00 | |
| 354 | Хангамжийн материал | 142,083,887.58 | 130,184,517.47 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,159,850.00 | 9,072,685.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 144,000.00 | |
| 35440 | Түлш шатах тослох материал | | 1,070,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 134,780,037.58 | 120,041,831.97 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,726,918,957.75 | 3,039,457,927.19 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,726,918,957.75 | 3,039,457,927.19 |
| 391 | Газар | 56,665,000.00 | 56,665,000.00 |
| 392 | Биет хөрөнгө | 3,670,253,957.75 | 2,982,792,927.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,009,464,064.01 | 2,009,464,064.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (46,488,689.64) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 192,045,902.23 | 192,045,902.23 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (142,404,205.98) | (166,937,549.24) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,900,729,943.65 | 3,921,194,843.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,398,807,697.88) | (3,012,289,145.29) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 213,377,407.85 | 213,377,407.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (104,221,456.13) | (127,643,906.38) |
| 39217 | Ном | 70,000.00 | 70,000.00 |
| 39301 | Програм хангамж | 935,000.00 | 935,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (935,000.00) | (935,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,179,869,723.64 | 3,457,469,645.08 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 147,161,895.34 | 30,759,586.19 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 147,161,895.34 | 30,759,586.19 |
| 413 | Өглөг | 99,470,017.15 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 33,594,111.43 | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 52,133,305.72 | |
| 4136 | Бусад өглөг | 13,742,600.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 13,742,600.00 | |
| 414 | Урьдчилж орсон орлого | 47,691,878.19 | 30,759,586.19 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 47,691,878.19 | 30,759,586.19 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,032,707,828.30 | 3,426,710,058.89 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,032,707,828.30 | 3,426,710,058.89 |

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
